



БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 02 өдөр

Дугаар A/01

Улаанбаатар хот

Г Хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтад өөрчлөлт оруулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор батлагдсан Бэлчээрийн менежмент төслийн нэгж, орон нутгийн өмчтэй төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 2.3, 5.7 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ Нь:

1. Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 7.1.11 дугаар заалтад өдрийн хоолны хөнгөлөлт 9000 (есөн мянга) төгрөгөөр тогтоосныг, 2023 оны 01 дүгээр сараас 14000 (арван дөрвөн мянган) төгрөг болгож өөрчилсүгэй.

2. Албан хаагчдад олгох өдрийн хоолны хөнгөлөлтийг зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулан тооцоолж нэмэгдүүлсэн бөгөөд байгууллагын төсөвт багтаан тооцож олгохыг Няглан бодогч (Ц.Мөнхдөл)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төслийн менежер (Б.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.УУГАНБАЯР

